



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/17

Арвайхээр

Нэмэгдсэн өртгийн албан татвар
төлөгчийн бүртгэлээс хасах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн А/02 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах журмын 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 50,0 сая төгрөгт хүрээгүй нь дараалсан 12 сарын татварын тайлангаар нотлогдсон "Спаркфайр" ХХК-нийг Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн төрлийн бүртгэлээс хассугай.

2. "Спаркфайр" ХХК (РД:3555429)-ний Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн гэрчилгээг хураан авч хүчингүй болгохыг Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн Татварын улсын байцаагч (Я.Наранчимэг)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭРДЭНЭСУВД



106181033